



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 183,069,122.52 (нэг зуун наян гурван сая жаран есөн мянга нэг зуун хорин хоёр төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 8 автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, хавсралтад заасан харьяа байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

132000054

1-r huraldaan.docx

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 01 дугаар сарын 09-ны өдрийн
17 дугаар тогтоолын хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, марк, улсын дугаар,	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл	ТӨБЗГ-ын 2024 оны 48 дугаар тогтоолоор тогтосон доод үнэ	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ
1.БАЯНХОНГОР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЛГИЙН ГАЗАР (төгрөг)						
1	Ариутгалын Дук машин, Потон форланд, 59-68 БНА улсын дугаар	26965	2005/2005	20,757,000.00	5,000,000.00	2,500,000.00
2.ДУНДГОВЬ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЛГИЙН ГАЗАР						
2	Суудлын автомашин, Ниссан сани, 53-07 ДУА улсын дугаар	FB15384597	2003/2010	7,200,000.00	3,500,000.00	1,750,000.00
3	УАЗ чиргүүл		2003	271,350.00	300,000.00	150,000.00
3.ЗАВХАН АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЛГИЙН ГАЗАР						
4	Ариутгалын Дук машин, Потон форланд, 59-06 ЗАА улсын дугаар	LVAV4JW655JO26971	2005/2005	23,902,000.00	5,000,000.00	2,500,000.00
4.ХОВД АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЛГИЙН ГАЗАР						
5	Суудлын автомашин, Ланд крузер 80, 12-24 ХОУ улсын дугаар	HDJ810060964	1995/2011	40,000,000.00	8,500,000.00	4,250,000.00

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар,	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл	ТӨБЗГ-ын 2024 оны 48 дугаар тсгтоолоор тогтоосон доод үнэ	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ
6	Хагас ачааны автомашин, Фермер УАЗ 390942-018, 55-04 ХОА улсын дугаар	330360A0432903	2010/2011	19,990,000.00	3,500,000.00	1,750,000.00
5.ХӨВСГӨЛ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР						
7	Ариутгалын Дук машин, Потон форланд, 71-63 ХӨА улсын дугаар	LVAV4JW605JO26960	2005/2005	40,948,772.52	5,000,000.00	2,500,000.00
6.ХЭНТИЙ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР						
8	Потон форланд ВJ5043 цистрен, 83-22 ХЭА улсын дугаар	LVBV3JBB19E470610	2009/2009	30,000,000.00	5 000,000.00	2,500,000.00
	НИЙТ ДҮН			183,069,122.52 (нэг зуун наян гурван сая жаран есөн мянга нэг зуун хорин хоёр төгрөг тавин хоёр мөнгө)	35,800,000.00 (гучин таван сая найман зуу)	17,900,000.00 (арван долоон сая есөн зуу)